

## Н.Энхболд: Австрали хүмүүсийн зан ааш, амьдралын хэв загвар монголтой их төстэй

169 Өчигдөр 18:10



*Австралийн Холбооны Улсын элчин сайдын яам Монголд албан ёсны нээлтээ хийсэн юм. Нээлтийн үеэр УИХ-ын гишүүн Н.Энхболд хэлэхдээ “ Монгол Улс шинэ нийгмийн тогтолцоонд шилжих үед Австралийн Засгийн газар шинэ хөтөлбөр хэрэгжүүлж, шинэ нийгмийн боловсрол, мэдлэг, онол, практикт тусалцаа үзүүлсэн нь Монголын хөгжилд хувь нэмэр оруулсан. Австралид сурсан монголчууд маань Монголдоо ирсний дараа Австрали-Монголын холбоо байгуулсан. Олон жилийн турш бид Австралийн байгууллагатай ажиллаж ирлээ. Өнөөдөр тус улс Элчин сайдын яамаа байгуулж, нээлтээ хийж байгаа нь Австралид сурсан монголчуудын оруулсан хувь нэмэр юм.” гэсэн юм. Үг хэлсний дараа Н.Энхболд гишүүнтэй ярилцлаа.*

### **-Монгол-Австралийн харилцааны түүх анх хэзээ үүссэн юм бэ?**

-Монгол-Австрали хоёр орны хооронд дипломат харилцаа 1972 онд байгуулсан. Ялангуяа 1990-ээд оны дунд үеэс монголчуудыг сургаж эхэлснээс хойш хоёр орны харилцаа идэвхжсэн. Өмнө нь үзэл суртлын ялгаанаас болж дипломат харилцаатай байсан ч өргөн цар хүрээтэй байгаагүй. Гэхдээ одоо боломж нээгдлээ.

### **-Хоёр орны ард түмэнд ижил төстэй зүйлүүд байдаг уу. Аль салбарт түлхүү хамтын ажиллагаатай байсан бэ?**

-Манай хоёр орны хувьд ижил, төстэй зүйл их бий. Австрали Улс өргөн уудам газар нутагтай, эдийн засгийн бүтцийн хувьд уул уурхай зонхилсон. Мөн Австрали хүмүүсийн зан ааш, амьдралын хэв загвар монголтой их төстэй. Энэ төстэй зүйлээ хоёр орны хөгжилдөө ашиглаж, Австралитай холбоотой байя гэж төгсөгчид маань жилийн жилд хүсэлт тавьдаг байлаа. Бидний үеийн болон хойших үеийн монголчууд маань Австралид сурч, мэдлэг, туршлага хуримтлуулж ирсэн. Бидний үед Австралийн Засгийн газрын тэтгэмжээр тав, зургаан монгол хүн сурдаг байсан. Тэнд төгсөөд ирсэн мэргэжилтнүүд одоо төрийн болон хувийн компани, бүх салбарт амжилттай ажилладаг. Гадаадын хэрэгжүүлсэн хөтөлбөр дотроос Австралийн Засгийн газраас хэрэгжүүлсэн хөтөлбөр хамгийн амжилттай нь байж магадгүй гэж бодож байна. Харин бид Австралийн Засгийн газарт танайд сурч ирсэн монголчууд эх орондоо ирээд их амжилттай ажилладаг болсон тухай олон

удаа санал тавьж, ярьсан. Үүний хүчинд жилд 24, аажмаар 36 монголчууд Австралид сурдаг болсон шүү дээ. Одоо сүүлийн үед Австралийн санхүү хүнд байгаа учир тэтгэлгээр сурах хүний тоогоо хассан.



**-Одоо Австралийн элчин сайдын яам нээгдэж байна. Хоёр орны харилцаанд ямар шинэ боломжууд бий болох бол?**

-Австралийн элчин сайдын яам нээгдэж байгаа нь маш чухал юм. Баяртай байна. Манай хамтрагч түнш, нөгөө талаар өрсөлдөгч орон юм. Австрали Улс уул уурхайн том орон. Нүүрсний салбарт том байр суурьтай, Хятадын том ханган нийлүүлэгч. Тиймээс бид зах зээлийн маягаар, эсвэл зэрлэг маягаар өрсөлдөх ёстой юм уу, нэг бол бие биенээ таньж, мэддэг, хэлхээ холбоо сайтай байдгийн хувьд бие биеэ дэмжин, хамтран ажиллах уу гэдгээ сонгох юм. Монголчууд хоёр улсын харилцаанд хувь нэмэр оруулах ёстой. Австралиудаас сурах зүйл ч их байна. Хүн хоорондын харилцаа, боловсролын харилцаа их сайн байгаа. Австрали Улс руу явах сонирхолтой монгол хүн Өмнөд Солонгосоос визээ авч явах боломжтой болж байгаа юм.

**-Уул уурхайгаас гадна өөр ямар салбарт илүү хамтарч ажиллах вэ?**

-Австрали Улсад мал аж ахуй, хөдөө аж ахуйн салбар нь илүү их хөгжсөн. Одоогоор манай улстай уул уурхай, боловсролын салбарт гүнзгий харилцаатай явж байгаа. Бусад салбаруудтай сүрхий хэлхээ холбоо байхгүй, харилцаа тогтоож амжаагүй байсан. Одоо Элчин сайдын яам нээгдэж байгаа болохоор мэдээж, бүх салбар луу илүү идэвхтэй ажиллах боломж гарна. Хөдөө аж ахуйн салбартаа Австрали Улс дэлхийн том экспортлогч орнуудын нэг. Энэ салбарт хамтрах боломж бий.

**Ярилцсан Б.Баярмаа**

**Эх сурвалж: [www.breakingnews.mn](http://www.breakingnews.mn)**

## **N. Enkhbold: The Australians have similarities in their character and lifestyle with Mongolians**

**Yesterday 18:10PM**

*Australia has officially opened its Embassy in Mongolia. During the opening ceremony, N. Enkhbold, MP stated that Australia contributed to Mongolia's development through providing assistance in education, knowledge, theory and practice and implementing the new program when Mongolia transitioned to the new social system. Mongolians who have graduated from Australian universities established the Australia-Mongolia Association on their return to Mongolia. We have been collaborating with Australian partners for many years. Today's opening of the Embassy is the outcome of contributions made by those Mongolians who have studied in Australia. After his speech, he was asked to give the following interview.*

- **When did collaboration between Mongolia and Australia start?**

In 1972, the diplomatic relationship between Mongolia and Australia was built. Particularly, this relationship has been strengthened with sending Mongolians to Australia for study purposes in 1990. Before this period, our relationship was limited due to ideological difference even though we had diplomatic relationships. However, new opportunities have opened now.

- **Are there similarities between nations? Which sector has received more collaboration?**

There are similarities between our two countries. Australia has a wide territory and its economy is dominated by mining sector. Also, the character and lifestyle of Australians have some similarities with Mongolians. In the last couple years, our alumni of Australian universities have been requesting to collaborate with Australia and that we need to make our similarities as an advantage to our development. Many Mongolians of our age and younger generation have studied in Australia accumulating knowledge and experience. During my times, only about 5-6 studied in Australia with the government scholarship. Those graduated have been working successfully in public and private agencies. I think the Australian government scholarship program is the most effective program among other programs, implemented by international agencies. We have informed many times that graduates from Australia have been doing well. As a result of our efforts, the number of Mongolians studying each year has been increased to 24, eventually to 36. However, due to economic recess, this number has decreased.

- **Now the Embassy has been opened. What new opportunities will come up in the bilateral relationship?**

- It is very important that the Embassy of Australia has opened. I am very happy that Australia is both our partner and competitor. Australia is a large country of mining. It has high ranking in the coal sector. It is a larger supplier from China. Therefore, we have to choose the way how our relationship can will be shaped: would it be a market-oriented or would it be a cruel competition, or would it be supporting relationship based on understanding and exchanging knowledge about each other. Mongolia should contribute to

the bilateral relationship. We need to learn more from the Australians. The relationship between our citizens and education sector has been well developed. Those who are travelling to Australia can get a visa in South Korea.

- **Where will the relationship expand more in, except mining?**
- Australia has a well-developed livestock breeding and agricultural sector. As of today, our relationship is limited to mining and education fields. We do not have much partnership in other sectors. Since the Embassy is here now, there will be more opportunities to expand the relationship to other sectors. Australia is one of the biggest exporters in agriculture. There is a chance to work together in this area.